



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997 оны 10 дугаар
сарын 23 өдөр

Дугаар А. 265

Улаанбаатар
хот

Хүрээлэн байгуулах тухай.

Нэг. Хот байгуулалтын үзэл баримтлал, бодлогыг хэрэгжүүлэх нийслэл хотыг шинжлэх ухааны үндэстэйгээр хөгжүүлэх зорилгоор, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн шийдвэрийг үндэслэн Улаанбаатар хотын захирагчийн эрхлэх ажлын хүрээнд ажиллаж буй "Зураг төсөл компани"-ийг нийслэлийн бүс нутгийн хөгжил, газар зохион байгуулалт, Улаанбаатар хот болон дагуул хот алслагдсан дүүргүүдийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, шинэчлэлийн болон барилгын зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, хотын түүх, уламжлалыг судлах үүрэг бүхий "Хот байгуулалтын хүрээлэн" болгон өөрчлөн зохион байгуулж, 1998 оны 1 дүгээр сарын 1 -ээс аж ахуйн тооцоон дээр ажлуулсугай.

Хоёр. "Хот байгуулалтын хүрээлэн"- гийн ерөнхий захиралаар архитектор, дэд доктор Майдар овогтой Оргилыг томилон ажлуулсугай.

Гурав. "Хот байгуулалтын хүрээлэн"- гийн бүтэц зохион байгуулалтыг нэгдүгээр хавсралтаар, дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Дөрөв. "Хот байгуулалтын хүрээлэн" байгуулагдсантай холбогдуулан нийслэлийн эдийн, засаг нийгмийн зорилттод тусгагдсан, хотыг хөгжүүлэх чиглэлийн төрөл бүрийн төсөл, хөтөлбөр, нарийвчилсан судалгаа, зураг төслийн ажилд шаардагдах хөрөнгийг, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тогтмол тусгаж, шийдвэрлүүлж байхыг нийслэлийн Засаг даргын Тамгын газар / н.Болдсайхан /, Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /н.Бат /, Санхүүгийн хэлтэс / н.Гонгор / нарт даалгасугай.

Тав. "Хот байгуулалтын хүрээлэн"-г ажлын байраар хангах асуудлыг судлан шийдвэрлэхийг Нийтлэг үйлчилгээний газар / н.Дашням / -т үүрэг болгосугай.




НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БОГООД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Дашням Ж.НАРАНЦАЦРАЛТ



Нийслэлийн Засаг даргын 1997 оны 10 дугаар сарын 23 өдрийн 26 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт.

"НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЗУРАГ ТӨСЛИЙН ХҮРЭЭЛЭН" – ГИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ





“НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭЛЭН”-гийн дүрэм

Нэг. Нийтлэг үндэслэл.

- 1.1 “Нийслэлийн хот байгуулалтын хүрээлэн” /цаашид хүрээлэн гэх / нь нийслэл хотыг шинжлэх ухааны үндэстэй хөгжүүлэх чиглэлээр бүс нутгийн хөгжлийн төсөл, нийслэлийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, шинэчлэл, хот суурин газрын ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын зураг төсөл боловсруулах, газрын үнэлгээ тогтоох, барилга байгууламжийн зураг төсөл зохиох, хот байгуулалтын мэдээлэлийн санг бүрдүүлэх, хотын түүх уламжлалыг судлах ажлыг эрхлэх үндсэн зорилго бүхий аж ахуйн нэгж мөн.
- 1.2 Хүрээлэнгийн үйл ажиллагаа нь эрдэм шинжилгээ, зураг төслөөр дамжуулан нийслэлийн эдийн засаг нийгмийн зорилтыг хот байгуулалт төлөвлөлтийн бодлоготой уялдуулан, нийслэлийн хот байгуулалтын үзэл баримтлал, бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.
- 1.3 Хүрээлэн нь Улаанбаатар хотын захирагчийн эрхлэх ажлын хүрээнд ажиллах аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байх бөгөөд өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчим дээр Төрийн болон Орон нутгийн өмчийн хууль, бусад хууль тогтоомжийн дагуу энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.
- 1.4 Хүрээлэн нь холбогдох дээд байгууллагын шийдвэрээр мөрдөж буй жишиг үнэ болон хэлэлцэлийн үнийн үндсэн дээр эрдэм шинжилгээ, зураг төсвийн үнийг тогтоох бөгөөд хийсэн ажилд ногдох гүйцэтгэлийн, цалингийн нормативийн хувийг тогтооно.
- 1.5 Хүрээлэн нь өөрийн үйл ажиллагаа үүрэг зорилтыг илэрхийлсэн билэгдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.
- 1.6 Хүрээлэн нь үйл ажиллагааныхаа үр дүнг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны өмнө тайлагнана.
- 1.7 Хүрээлэн нь:
 - Хот төлөвлөлтийн зураг төсөл
 - Архитектур төлөвлөлт
 - Бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт
 - Хот судлал, мэдээлэлийн секторуудээс бүрдэнэ.
- 1.8 Хүрээлэнг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах асуудлыг Нийслэлийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэнэ.

Хоёр. Хүрээлэнгийн үүрэг.

- 2.1 Нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах шаардлагаар, эдийн засаг нийгмийн шинэ нөхцөлтэй уялдан хот байгуулалт, төлөвлөлтийн ажилд тавигдаж буй зорилтуудыг хэрэгжүүлэх үүднээс нийслэлийн бүс нутгийн хөгжил, газар зохион байгуулалт, хот, суурины ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон барилга байгууламжийн зураг төсөл зохиох, эдгээртэй холбогдолтой судалгаа хийх, санал дүгнэлт гаргах
- 2.2 Нийслэлийн хот байгуулалт, барилгажилт, барилга байгууламжийн ашиглалт, инженерийн шугам сүлжээний өөрчлөлт шинэчлэлтийн талаарх мэдээлэлийг толгой компьютерт тогтмол оруулж, хот байгуулалтын мэдээлэлийн санд баяжилт хийж, захиалагч болон хэрэглэгч, хэрэгжүүлэгч байгууллагуудыг мэдээлэлээр хангах.
- 2.3 Дээрх мэдээлэлийн дагуу хотын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэнд судалгаа хийж, жижүүрийн зураглал хөтлөх
- 2.4 Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтын шугамаар боловсруулсан, нийслэлд баригдах барилга, байгууламж, хот байгуулалтын зураг төсөл, хөтөлбөрт санал дүгнэлт өгөх.
- 2.5 Зураг төсөл, судалгааны ажилд тэргүүний техник технологи нэвтрүүлэх, автоматжуулах, мэргэжилтнүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, давтан сургах, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах арга хэмжээ авах.
- 2.6 Бүс нутгийн төлөвлөлт, газар зохион байгуулалт, техник эдийн засгийн үндэслэл, хот, суурины ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа холбогдох норм, норматив, стандартыг мөрдөх.
- 2.7 Нийслэлийн эдийн засаг, нийгмийн онцгой ач холбогдол бүхий, бүс нутгийн хөгжлийн болон, хот байгуулалтын төсөл, техник эдийн засгийн үндэслэл, хөтөлбөр боловсруулахад холбогдох яам, газрын саналыг авах.
- 2.8 Боловсруулсан зураг төсөв, төсөл, хөтөлбөрийн эх хувийг холбогдох баримт материалын хамт архивт хадгалж, хотын техникийн архивийг хариуцах

Гурав. Хүрээлэнгийн эрх.

- 3.1 Улсын хэмжээний онцгой ач холбогдол бүхий томоохон зураг төсөл, судалгааны ажил боловсруулахдаа холбогдох мэргэжилтнүүдийг урьж тодорхой нөхцөл, гэрээгээр оролцуулах.
- 3.2 Нийслэлийн бүс нутгийн хөгжлийн төсөл, нийслэлийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, шинэчлэлийн зураг төсөл, судалгааны ажилд шаардагдах мэдээлэл, нэмэлт материалуудыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжээр гаргуулах.

- 3.3 Хүрээлэнгийн үйл ажиллагааг өргөтгөх, зураг төслийн байгууллагуудын туршлага судлах, нэвтрүүлэх зорилгоор гадаад дотоодын зураг төслийн байгууллагуудтай гэрээ байгуулж хамтран ажиллах.
- 3.4 Улс орон нутгийн төсөвт татвар, хураамж, төлбөр төлсний дараа өөрийн мэдэлд үлдэх хөрөнгийг хөдөлмөрийн хөлс, нийгмийн болон үйлдвэрлэлийг хөгжүүлэх болон бусад арга хэмжээнд зарцуулах.
- 3.5 Ажилчдын хөдөлмөрийн хөлсийг тэдний ажлын эцсийн үр дүнтэй уялдуулан нэмэгдүүлэх буюу бууруулан олгох журмыг хамтын гэрээнд тусгасны үндсэн дээр тогтоох
- 3.6 Улсын болон нийслэлийн даалгавартай ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх ба шаардлагатай тохиолдолд бусад аж ахуйн нэгж байгууллагын захиалга авч гэрээ байгуулан ажиллах.
- 3.7 Эрдэм шинжилгээ, зураг төслийн ажилд шаардлагатай багаж, техник тоног төхөөрөмж, норм норматив, материалыг бүрдүүлэхэд санхүүгийн дэмжлэг авах

Дөрөв. Хүрээлэнгийн удирдлага.

- 4.1 Хүрээлэн нь Нийслэлийн Засаг даргын эрхлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын ерөнхий архитекторын удирдлага дор үйл ажиллагаагаа явуулна.
- 4.2 Хүрээлэнгийн ерөнхий захиралыг Нийслэлийн Засаг даргын захирамжаар томилон ажиллуулна.
- 4.3 Хүрээлэнгийн захирал нь зураг төслийн техникийн болон технологийн шаардлагыг хангах зорилгоор, эрдэмтэн нарийн бичгийн дарга бөгөөд ерөнхий инженертэй байна.
- 4.4 Зураг төслийн шилдэг шийдэл, судалгааны ажил, нийгмийн томоохон асуудлын хамрах чиглэлээр оновчтой шийдэл гаргах зорилгоор "Эрдэм техникийн зөвлөл" ажиллуулна.
- 4.5 Зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг ерөнхий захирал батална.
- 4.6 Захирал нь хүрээлэнгийн үйл ажиллагааны хүрээнд мөрдөх тушаал, заавар, журам болон бусад акт баримт гаргана.
- 4.7 Захирал нь хүрээлэнг төлөөлж дараахи эрх эдэлнэ.
- Хүрээлэнгийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулан батлуулж биелэлтийг хангуулах.
 - Хүрээлэнгийн эрхлэх ажлын хүрээнд гадаад дотоодын байгууллага, иргэдтэй шууд харьцаж гэрээ хэлцэл хийх
 - Хүрээлэнгийн эд хөрөнгийг Монгол улсын хууль тогтоомж, дүрмийн дагуу ашиглах, зарцуулах
 - Хүрээлэнгийн нийт ажилтан ажилчид, салбарын болон нэгжийн удирдлага, бусад албан тушаалтаныг томилох, ажлаас чөлөөлөх, цалингийн хэмжээг тогтоох

- Хүрээлэнгийн бүтэц зохион байгуулалтыг жилийн ажлын хэмжээтэй уялдуулан өөрчлөх, боловсронгуй болгох, орон тоо цалингийн санг тогтоох
- Хүрээлэнгийн гүйцэтгэх ажлын хэмжээ, эрдэм шинжилгээ, зураг төслийн үнэлгээг холбогдох дээд байгууллагын шийдвэр болон хэлэлцэлийн үнийг үндэслэн тогтоож мөрдөх.
- Хүрээлэнгийн гүйцэтгэж буй ажил, үйлдвэрлэл технологийн болон судалгааны нууцад хамаарах мэдээллийг тогтоож хяналт тавих.

Тав. Хүрээлэнгийн дүрмийн сан.

- 5.1 Хүрээлэнгийн дүрмийн сан нь үндсэн ба эргэлтийн хөрөнгө бусад нөөцөөс бүрдэх ба түүнийгээ өөрчлөн тогтоох буюу арвижуулан нэмэгдүүлэх арга хэмжээ авч тайлан тэнцэлдээ тусгаж байна.
- 5.2 Хүрээлэнгийн хөрөнгө нь үйлдвэрлэл, ажил үйлчилгээнээс олсон орлого, хууль тогтоомжийн дагуу буй болсон бусад эх үүсвэрээс бүрдэнэ.